ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

МОНГОЛЫН ХОГ ХАЯГДЛЫГ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

# ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ГАРЦ ШИЙДЭЛ

2019.10.21

# АГУУЛГА

1 ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2 ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ГАРЦ ШИЙДЭЛ

3 ЭДИЙН ЗАСГИЙН УРАМШУУЛАЛ, САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ГАРЦ ШИЙДЭЛ

4 ХҮНИЙ НӨӨЦ, ТЕХНОЛОГИ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ГАРЦ ШИЙДЭЛ

5 БОРЛУУЛАЛТ, ЗАХ ЗЭЭЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ГАРЦ ШИЙДЭЛ

6 ЧАНАР, СТАНДАРТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ГАРЦ ШИЙДЭЛ

# ДЭЛХИЙ НИЙТИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА ӨНӨӨДӨР ХААШАА ЧИГЛЭЖ БАЙНА ВЭ?

## ШУГАМАН ЭДИЙН ЗАСАГ




Үйлдвэрлэл – хэрэглээ – хаях, устгах замаар байгалийн нөөцийн үр ашиггүй, замбараагүй зарцуулалт

## ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ




Дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх замаар байгалийн нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

**Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа нь 3 тулгуурт суурилан тогтвортой хөгжих дэлхий нийтийн “Тогтвортой хөгжлийн зорилго 2030” урт хугацааны бодлогын баримт бичигт нийцэж байна.**




1. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичиг (2016 он)
2. Монгол улсын “Ногоон хөгжлийн бодлого” (2014 он)
3. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” (2015 он)
4. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2016 он)
5. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” (2018 он)
6. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги 2015-2020 он (2015 он)
7. “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр” (2014 он)

**Хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг 2020 онд нийт хог хаягдлын 20%-д, 2025 онд 30%-д, 2030 онд 40%-д хүргэх**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

МОНГОЛЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОЛБОО

# ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГТ ЗАЙЛУУЛСАН НИЙТ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ, (тонн)




## ДАХИН БОЛОВСРУУЛАХ БОЛОМЖТОЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ, (2018 он, тонн)

**Нийт энгийн хог хаягдлын 50% буюу 1.5 сая тонныг дахин боловсруулах боломжтой хог хаягдал эзэлж буй боловч одоогоор 10 хүрэхгүй хувийг л дахин боловсруулж байна.**

| | |
|---|---|
| ЦААС, ЦААСАН БҮТЭЭГДЭХҮҮН | 9.03 % |
| ШИЛ, ШИЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ | 3.22 % |
| ХӨНГӨН ЦАГААН БҮТЭЭГДЭХҮҮН | 0.5 % |
| ХАР ТӨМӨРЛӨГӨН БҮТЭЭГДЭХҮҮН | 9.7 % |
| ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮН | 9.6 % |
| БУСАД БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ГАРАЛТАЙ | 67.9 % |

Эх сурвалж : Байгаль орчин, аялал жуулчлалын яам "Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он"

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

МХХДБҮХолбооны гишүүн байгууллагууд нь дараах чиглэлүүдээр дахин боловсруулах үйл ажиллагаа явуулж байна

- ✓ Хуванцар (PEP, PET, PVC, PP, LDPE, HDPE)
- ✓ Хаягдал моторын тос дахин боловсруулах
- ✓ Хаягдал шил дахин боловсруулах
- ✓ Хаягдал дугуй дахин боловсруулах
- ✓ Хаягдал кардонон цаас дахин боловсруулах
- ✓ Хаягдал хөнгөн-цагаан дахин боловсруулах
- ✓ Хаягдал аккумулятор, хар тугалга дахин боловсруулах
- ✓ Арьс ширний үйлдвэрийн хаягдал дахин боловсруулах
- ✓ Хүнсний үлдэгдэл, өөх тос дахин боловсруулах







МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН “ЭКО-ПАРК” ТӨСӨЛ

ЭКОПАРК УЛААНБААТАР

**247,000,000,000 /MNT/**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

**2017-2032**
ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

НАРАНГИЙН ЭНГЭР
ЦАГААН ДАВАА
**2**
БАЙРШИЛД

**174.07**
ГА ТАЛБАЙ ГАЗАР





**13**
ТӨРЛИЙН ХОГ ХАЯГДЛЫГ

**19**
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮД

**4**
ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАН ЯЛГАХ ҮЙЛДВЭР

**1**
АВТОБААЗ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ АРИУТГАЛЫН ТӨВ

**1**
ҮНСНИЙ ЛАНДФИЛИЙН БАЙГУУЛАМЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

МОНГОЛЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОЛБОО

# АШИГЛАЛТААС ХАСАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЯВЦАД ҮҮСЭХ ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН “АВТОРЕСАЙКЛИНГ ПАРК” ТӨСӨЛ

Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн ашиглалтын явцад үүсэн гарах хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэл, технологийн “Авторесайклинг парк” төслийг ”Хан-Уул дүүргийн 13 хорооны нутаг дэвсгэрт 30 га газарт хэрэгжүүлэхээр Зам тээвэр, хөгжлийн яамтай хамтран ажиллаж байна.





## “АВТОРЕСАЙКЛИНГ ПАРК” ТӨСЛИЙГ СОНИРХОЖ БУЙ ТАЛУУД





ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# КАРИТАС ЧЕХ РЕПАБЛИК ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН НӨӨЦИЙН ҮР АШИГТАЙ БАЙДАЛ, ЦЭВЭР ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ



# ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ГАРЦ ШИЙДЭЛ

| № | Тулгамдсан асуудал | Гарц шийдэл |
|---|---|---|
| 1 | Дахивар нөөц буюу дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бүрдээгүйгээс дийлэнхи хаягдлыг ангилан ялгахгүйгээр хогийн төвлөрсөн цэгүүдэд шууд хүргэж, газарт булж устгаж байна. | Эх үүсвэр дээр нь ангилан ялгалт хийж, сум бүрт дахивар нөөц бэлтгэх цэг, аймаг бүрт дахивар нөөц хадгалах агуулах байгуулан түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх.<br>1. Аймаг, нийслэлийн ИТХ нь энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмаа баталж, мөрдүүлэх;<br>2. Бүх нийтэд, хог хаягдлын тухай боловсрол олгох; |
| 2 | Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, ААНБ-д эдийн засгийн урамшуулал олгох асуудал шийдэгдэхгүй, хүлээгдсээр байна. | 1. “Хог хаягдлын тухай” хуулийн 40.4-т заасан “Эдийн засгийн урамшуулал олгох журам”;<br>2. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилго бүхий “Эко төлбөрийн тухай” хууль;<br>3. 3. “Эдийн засгийн урамшууллын сан” байгуулан хог хаягдлын менежмент, дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаанд оролцогч бүх талуудад тохирох урамшууллыг олгож байх; |

# ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ГАРЦ ШИЙДЭЛ

| № | Тулгамдсан асуудал | Гарц шийдэл |
|---|---|---|
| 3 | Дахин боловсруулах үйлдвэрүүдийг үүсч буй дахивар нөөцийн хэмжээнд тохируулж бодлогоор байгуулах шаардлагатай. | Улсын хэмжээнд 1 жилд үүсэх хог хаягдлын баланс гаргаж, дахин боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг зөв тооцоолж, нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгөөр үйлдвэрүүдийг барьж байгуулах, хөгжүүлэх; |
| 4 | ДБҮ-ийг кластераар хөгжүүлж дахин боловсруулсан түүхий эдээр импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, | ДБҮ-ийг үйлдвэрлэл, технологийн парк хэлбэрээр зохион байгуулалттайгаар байгуулах шаардлагатай. |
| 5 | ДБҮ-ийн салбарт шууд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, санхүүжилт, хөрөнгө оруулалт дутагдалтай байна. | ДБҮ-ийн салбарыг тогтвортой санхүүжилт, хөнгөлөлттэй зээл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжин хөгжүүлэх шаардлагатай. |
| 6 | Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах шаардлагатай байна. | Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулж байгалийн нөөц баялгийг хэмнэн хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж байгаа нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан татварын бодлогоор дэмжих. |
| 7 | Импортоор авч оруулж буй дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-ийн албан татвараас чөлөөлөх. | Гаалийн татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтанд дахин боловсруулах үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг оруулах. |

# ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ГАРЦ ШИЙДЭЛ

| № | Тулгамдсан асуудал | Гарц шийдэл |
|---|---|---|
| 8 | Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрүүд мэргэжилтэй, мэргэшсэн ажиллах хүчин, хүний нөөцийн хомсдолтой байна. | Үйлдвэр аж ахуйн нэгжийн захиалгаар салбарын инженер, техникийн ажилтнуудыг гадаад, дотоодын их дээд сургуулиудад, мэргэжилтэй ажилчдыг дотоодын МСҮТөвд сургаж, бэлтгэхэд бодлогоор дэмжлэг үзүүлэх. |
| 9 | Дахин боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллагсад нь хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажиллаж байна. Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах шаардлагатай. | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх итгэмжлэл бүхий төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаар салбарын ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг тогтоолгох ажлыг хийж, ажиллагсдын нийгмийн асуудалд анхаарлаа хандуулах. |
| 10 | Үнийн өсөлт үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлж байна. Тухайлбал эрчим хүчний тариф байнга нэмэгдэж байгаа нь дарамт болж байна. | Эдийн засгийн урамшуулал олгох нэг хэлбэр нь эрчим хүч, ус, дулааны үнэ тарифад хөнгөлөлт үзүүлэх, үнэ тарифыг тодорхой хугацаанд тогтворжуулах замаар хэрэгжиж болох юм. |

# ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ГАРЦ ШИЙДЭЛ

| № | Тулгамдсан асуудал | Гарц шийдэл |
|---|---|---|
| 11 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулагдаж буй худалдан авалтад оролцох оролцоо бага байж ирсэн. | 1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын гарал үүсэлтэй болон хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээд”-д давaa эрх олгоно гэж заасан байдаг.<br>2. Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-д 14 төрлийн 156 нэрийн бараа орсон. |
| 12 | Дахин боловсруулсан бүтээгдэхүүний эдийн засгийн боломж, үр ашигтай байдал, зах зээлд нэвтрүүлэхэд тулгарах саад бэрхшээл болон техникийн ба чанарын өрсөлдөх чадварыг баталгаажуулах шаардлагатай | Дахин боловсруулсан бүтээгдэхүүний стандарт боловсруулах, тохирлын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж хийх шаардлагатай. Үүнд, төрийн захиргааны төв байгууллагууд хариуцсан салбараас нь үүсэх хаягдлыг дахин боловсруулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний стандарт, нормативыг боловсруулж батлуулахад санхүү, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах. |
| 13 | Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарт инновацид суурилсан дэвшилтэт техник, технологи, өндөр технологийг нэвтрүүлэх замаар үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай. | Гадны технологийг нутагшуулахаас гадна Шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллаж, эрдэмтдийн инноваци, өндөр технологи бүхий бүтээгдэхүүний судалгаа шинжилгээний ажлын үр дүнг дахин боловсруулах үйлдвэрлэлд нэвтрүүлэх нь салбарын хөгжлийг түргэтгэх, үр ашгийг нэмэгдүүлэх үндсэн аргын нэг юм |

# ТӨР, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ БУЙ ХҮСЭЛТ

**Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө Монгол улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хандаж дараахи хүсэлтийг гаргаж байна. Үүнд:**

**1. Төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн “Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх;**

**2. Дахин боловсруулах үйлдвэрлэлийг тогтвортой санхүүжилт, хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих;**

**3. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэн “Эдийн засгийн урамшууллын сан” байгуулж, дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаанд оролцогчдыг урамшууллаар дэмжих;**

**4. Дахин боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэхэд болон хүний нөөцийн хөгжил, ажиллагсдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх;**

**5. Дахин боловсруулах үйлдвэрлэлийн техникийн ба чанарын өрсөлдөх чадварыг сайжруулах, инновацид суурилсан дэвшилтэт техник, технологи, өндөр технологийг нэвтрүүлэх замаар салбарын хөгжлийг түргэтгэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# УРИАЛГА

**Зөвлөлгөөнд оролцогчдод хандаж дараахи уриалгыг гаргаж байна.**



**- Хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж хог хаягдал үүсгэхээс татгалзах, үүсэх хэмжээг багасгах, нэгэнт үүссэн хаягдлаа ангилан ялгаж дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйлдвэрийн түүхий эд - дахивар нөөцөөр бэлтгэн нийлүүлж хэвших;**

**- Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ дахивар нөөц сонгож, хаягдалгүй болон хамгийн бага хаягдал гаргах байгаль орчинд ээлтэй технологи судалж нэвтрүүлэх;**

**- Дахин боловсруулсан, сэргээн ашигласан бүтээгдэхүүн худалдан авах замаар ногоон худалдан авалтыг дэмжих;**

***“Хог хаягдал бол байх ёстой газартаа очоогүй байгаа түүхий эд юм” Д.И.Менделеев***

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА